



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 4/65-

Хэрлэн сум

Эд хөрөнгийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит байгууллагын Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дансанд бүртгэлтэй 34 нэр төрлийн 126,167,500 төгрөгийн балансын үнэтэй, 112,920,825 төгрөгийн үлдэх өртөгтэй эд хөрөнгийг Бор-Өндөр сумын Хот тохижилт Орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эд хөрөнгийг шилжүүлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА